



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙН СУУРИЛУУЛАЛТ,
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

| 1.Ерөнхий мэдээлэл | | | | | | |
|--|---|---------------|-------------------|---------------------|--|---------------|
| Өргөдөл гаргасан огноо | Он сар өдөр | | | | | |
| Зөвшөөрөл хүсэгчийн нэр | | | | | | |
| Регистрийн дугаар | | | | | | |
| Албан хүсэлт | Манай байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.12-т заасан харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу тусгай зөвшөөрөл олгоно уу. [нэмэлт мэдээллийг дурьдаж болно] <input type="checkbox"/> Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл | | | | | |
| 2.Хаягийн мэдээлэл: | | | | | | |
| Хаяг байршил | Аймаг/ хот | | | | | |
| | Сум/дүүрэг | | | | | |
| | Баг/хороо | | | | | |
| | Гудамж,байр | | | | | |
| | Тоот | | | | | |
| Утас | | | | | | |
| Цахим хуудас | | | | | | |
| Цахим хаяг | | | | | | |
| 3.Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл: | | | | | | |
| Албан тушаал | Овог / Нэр | Утасны дугаар | | | Цахим хаяг | |
| Захирал | | | | | | |
| Зөвлөх инженер / Мэргэшсэн инженер | | | | | | |
| Үйл ажиллагаа хариуцсан менежер | | | | | | |
| 4.Инженер, техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээлэл: | | | | | | |
| № | Овог нэр | Албан тушаал | Регистрийн дугаар | Сургууль төгссөн он | Ажиллаж байсан байгууллага, албан тушаал | Ажилласан жил |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

- Шаардаж буй 3 ажилтны мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар, сертификат хавсаргав.
- Шаардаж буй 3 ажилтны хөдөлмөрийн харилцаа үүсгэж буй гэрээний хуулбарыг хавсаргав.
- Шаардаж буй 3 ажилтны нийгмийн даатгал төлдөг талаарх тодорхойлолт хавсаргав.

Жич: Дээрх ажилчдын мэдээлэл тус хорооны мэдээллийн санд бүртгэгдэнэ. Ажилтан нь зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар үндсэн ажил олгогчоос албан бичгээр зөвшөөрөл ирүүлнэ. Өмнөх ажил олгогчтой гэрээг цуцалсан бол хөдөлмөрийн харилцааны гэрээг дуусгавар болгосон тушаал, шийдвэрийн хуулбарыг ирүүлж мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

5. Туршлага:

- Шаардаж буй 3 ажилтны харилцаа холбооны шугам, сүлжээг суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх төрлөөр тусгай зөвшөөрөлтэй компанид ажиллаж байсанг нотлох мэдээлэл /ажил олгогчийн тодорхойлолт, хөдөлмөрийн харилцааны гэрээ гэх мэт/-ийг хавсаргав.
- Эсхүл шаардаж буй 3 ажилтны харилцаа холбооны шугам, сүлжээг суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг хөдөлмөрийн харилцаа үүсгэх гэрээнээс гадна бусад гэрээгээр хийж байсан бол хүлээлгэж өгсөн ажлын акт, захиалагчийн тодорхойлолт зэргийн хуулбар хавсаргав.

6. Техник хэрэгслийн иж бүрдлийн мэдээлэл

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 105 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага"-ын 2.1 дэх хэсэгт "тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа, ажил үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаарх нотлох баримт, гэрээг, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо зэргийг багтаасан бизнес төлөвлөгөөг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргаж ирүүлнэ." гэж заасан.

Үүнд: техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаарх нотлох баримтын хүрээнд (захиалга баталгаажуулсан гүйлгээний баримт, худалдах худалдан авах гэрээ, ибаримт гэх мэт) эсхүл түрээсийн гэрээгээр ашиглах бол техник хэрэгслийн түрээсийн гэрээний хуулбар, тээврийн хэрэгслийн хувьд өмчлөгч болохыг нотолсон тээврийн хэрэгслийн гэрчилгээг хавсаргаж тус тус ирүүлэх; (дан ганц фото зургыг тооцдоггүйг анхаарах) Үүнд:

1. Техник хэрэгсэл:

- 1.1. Шилэн кабелийн залгааны машин;
- 1.2. Битүүмжлэл бүхий машин (шилэн кабелийн залгаа, муфьт хийхэд зориулагдсан).

2. Дээрх тоног төхөөрөмжийн талаарх нотлох баримт, гэрээг, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо зэргийг багтаасан бизнес төлөвлөгөөг хавсаргав.

- 2.1. Бизнес төлөвлөгөө

7. Өргөдөл гаргагчийн баталгаа:

Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан холбогдох нөхцөл шаардлагад нийцүүлэн тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв.

Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал, ташаа мэдээлэл орсон тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээх болно.

Харилцаа холбооны салбарын холбогдох журам, стандарт, норм, норматив, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 105 тоот тогтоолын хавсралтаар баталсан Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ)-ыг ханган ажиллахаа баталгаажуулав.

Энэхүү зөвшөөрлийн хүсэлтэд ашигласан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хүний хувийн мэдээлэлд хамаарах эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, боловсрол, нийгмийн даатгалын мэдээллийг мэдээллийн эзнээс хуульд заасан хэлбэрээр гаргуулан авч, хүргүүлэв.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр

Албан тушаал

Гарын үсэг

Огноо

Тамга:

--oOo--